



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/115

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Замын сангийн санхүүжилтээр хэрэгжих /Буянт сум, Цагаанбургас баг, Захын гуу, Зэгстээн гол/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Б.Батсүх - Худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Ц.Нямбаяр - Цаг уурын инженер

Н.Жавзанханд - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Ч.Мөнхтөр - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Д.Дариймаа - Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж, үр дүнг танилцуулахыг үнэлгээний хорооны дарга /Б.Батсүх/-д даалгасугай.

3. Дээрхи төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн хадгалахыг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Д.Дариймаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД